

МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА ШИНЭ ЗУУНЫ ГАРАНД

Б. Сэржав*

Дипломат харилцаа тогтоосноос хойших үе, өөрөөр хэлбэл, ХХ зууны төгсгөлийн 30-аад жилийн хугацаанд Монгол—Японы харилцаа улс төр, эдийн засаг, худалдаа, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэг гээд бүх салбарыг хамран тогтвортойгоор урагшлан хөгжиж ирлээ. Ялангуяа Монгол улс түүхэндээ 70-аад жил дагаж баримталж ирсэн социалист нийгмийн тогтолцоог үндсээр нь халж, эрх чөлөө, ардчиллын зарчимд тулгуурласан биеэ даасан гадаад бодлого хэрэгжүүлж эхлэн, Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд үндсэн өөрчлөлт гарснаар 1990 оноос хойш Япон улстай тогтоосон харилцаа нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгаанаас ангид ард түмний эрх ашигт нийцэн хөгжих боломж сая бүрдэж, урьд өмнө байгаагүй эрч далайц, өргөн цар хүрээг хамран шинэ ХХI зууны босгоор алхлаа. Хүний нийгмийн хөгжлийн шинэ зуунд Монгол, Япон хоёр улсын харилцаа ямар чиглэлтэй байж, аль хирийн түвшинд хүрч хөгжих тухай асуудал өнгөрсөн хугацаанд ерөнхий хандлага, өнгө аясын хувьд зарим талаар тодорхой болж ирлээ. Хоёр орны харилцааны цаашид тулгуурлах үзэл санаа, зарчмын талаар 1998 оны тавдугаар сарын 14-ний өдөр Токио хотноо гаргасан “Монгол улс, Япон улсын найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д заахдаа “Хоёр орны харилцаа сүүлийн жилүүдэд эрх чөлөө, ардчилалын нэгдмэл үнэт зүйлст тулгуурлан өргөжин хөгжиж байгаад хоёр тал сэтгэл ханамжтай буйгаа тэмдэглээд, харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх замаар Иж бүрэн түншлэлийн харилцааг ХХI зуунд бэхжүүлэх зорилт дэвшүүлснээ дахин нотлов”¹ хэмээн тодорхойлсон юм. Энэхүү зорилтыг дэвшүүлэн тавих үндэслэл, хоёр орны харилцааны үндэс суурийг Монгол улсын засгийн газар, Япон улсын засгийн газар 1990 оны гуравдугаар сар, 1991 оны наймдугаар сар, 1993 оны

* Б.Сэржав - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд профессор, доктор /Ph/

арван нэгдүгээр сард гаргасан хэвлэлийн хамтарсан Мэдээнүүд, 1997 оны хоёрдугаар сард гаргасан Хамтарсан мэдэгдэл, тэдгээрийн агуулгаар бүрдүүлж ирсэн юм гэдгийг дээрх Хамтарсан мэдэгдэлд цохон тэмдэглэсэн юм.

Хоёр орны харилцааны үндсэн чиглэл зарчмыг тусгасан дээрх баримт бичгүүдэд Монгол, Японы хамтын ажиллагааг харилцан ашигтай, нэг нь нөгөөгөө нөхөж чадах, дэлхийн зах зээлд гарч чадахуйц бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөхөд чиглүүлэх талаар санал нэгтэй байгаагаа хоёр тал тэмдэглэж байсан юм.

Аж үйлдвэр, шинжлэх ухаан техник өндөр хөгжсөн оронтой түүний ашиг сонирхлыг өөрийнхтэйгөө зөв хослуулж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь шилжилтийн үеийн өнөөгийн шатанд төдийгүй Монгол улсын эдийн засгийн цаашдын хөгжилд нэн чухал ач холбогдолтой билээ. Японы өндөр технологи, монголын мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг зөв хослуулан ашиглах өргөн боломж байгаа гэдэг нь илэрхий.

Япон, Монголын орчин үеийн шинэ харилцааны эхийг тавьсан Ерөнхий сайд асан Т.Кайфу “Энэ харилцаа XXI зуунд чиглэж хөгжинө. Аль ч нам засгийн эрх барьсан Япон, Монголын харилцаа хэвээр үргэлжлэх болно” гэж батлан хэлсэн юм. Энэ бүхэн нь Монгол Японы харилцаа цаашид улам амжилттай хөгжих ирээдүй байгааг нотлон харуулж байна.

Хоёр орны иж бүрэн түншлэлийн харилцаа хэмээх ойлголтод нэгдүгээрт, харилцан ойлголцсон, бие биеэ хүндэтгэсэн, улс төрийн урт удаан харилцаа, хоёрдугаарт, олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцсэн худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай түншлэл, гуравдугаарт, соёл, боловсрол, шинжлэх ухаан-технологи, хүмүүнлэгийн салбарыг хамарсан харилцаа, дөрөвдүгээрт, дэлхий дахины глобал болон бүс нутгийн харилцааны асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах² явдлыг хамруулан үздэг юм байна. Эдгээр зарчмыг баримтлан, Монгол, Японы харилцааг ирэх зуунд хөгжүүлэхдээ өөр өөрсдийн өвөрмөц онцлог, тодорхой нөхцлийг харилцан бодолцож, биеэ даасан, эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг бататган хөгжүүлэх чиг шугамыг хоёр тал барьж байна. Шинэ зуун эхлээд байгаа өнгөрсөн богино хугацаанд хоёр орны харилцаанд чухал ач холбогдолтой хэд хэдэн үйл явдлууд болж өнгөрлөө.

Монгол улсын Засгийн газрын ерөнхий сайд Н. Энхбаярын

2001 оны хоёрдугаар сарын 13-18-нд Япон улсад хийсэн албан ёсны айлчлал нь Монгол улсын Засгийн газар Япон улстай харилцах харилцаанд ихээхэн ач холбогдол өгч байдгийн илэрхийлэл болсон юм. Айлчлалын үеэр Ерөнхий сайд Н. Энхбаяр Япон улсын Цог Жавхлантай Эзэн хаан Акихитод бараалхаж, Парламентийн Төлөөлөгчдийн Танхимын дарга Т.Ватанүки, Зөвлөхүүдийн Танхимын дарга Ю. Иноүэ нартай уулзав. Япон улсын Засгийн газрын Ерөнхий сайд Ё. Моритой уулзаж хэлэлцээ хийв. Монгол, Японы дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхий сайд Ё. Мори хоёр орны харилцаа сүүлийн жилүүдэд ардчилал, эрх чөлөө, хүний үндсэн эрх гэсэн нэгдмэл үнэт зүйлст тулгуурлан бэхжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэхийн хамт “Монгол улсын өөрчлөлт шинэчлэлтийг дэмжих Япон улсын Засгийн газрын бодлого өөрчлөгдөхгүй”³ гэдгийг мэдэгдэв. Ерөнхий сайд нар харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх замаар хоёр орны иж бүрэн түншлэлийн харилцааг улам батжуулахын төлөө цаашид хүчин чармайлт гаргахаа нотолсон юм.

Айлчлалын үеэр хоёр тал “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр” байгуулж гарын үсэг зурсан нь Монгол улсад Японы хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн эрх зүйн үндсийг бүрдүүлж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Гадаадын хөрөнгө оруулалт нь дотоодын хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалыг нөхөх, зах зээлийн тогтолцооны нөхцөлд аж ахуйг хөтлөх удирдлагын арга барилыг боловсронгуй болгох, орчин үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлэх, ажилгүйдлыг багасгах, экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах чухал хүчин зүйл гэдэг нь ойлгомжтой.

Монгол улс газар нутаг уудам, хүн ам цөөнтэй, байгалийн баялаг ихтэй, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц сайтай, байгалийн цэвэр бүтээгдэхүүн гаргах боломж бүхий цэвэр ариун байгальтай, түүний дээр улс төрийн тогтвортой байдалтай, нээлттэй эдийн засагтай, ОХУ, БНХАУ хэмээх хоёр том зах зээлд нэвтрэх өргөн боломжтой, боловсролтой хүн амтай зэрэг өөрийн давуу талаа ашиглан Японы талын хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэх бололцоотой. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг зохистойгоор бүрдүүлэхийн зэрэгцээ гадаад сурталчилгааг чанаржуулах, идэвхжүүлэх, орчин нөхцлөө зөвөөр ойлгуулах, хөрөнгө

оруулагчдын ашиг сонирхлыг төрүүлэх зэрэг үйл ажиллагааг өөрийн зүгээс уйгагүй явуулах нь Японы хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ашиг тусаа өгөх арга хэмжээ болох биз ээ. Үүний дээр хөрөнгө оруулалтад харилцан бие биеэ сайн танин мэдээгүй тохиолдолд эрх зүйн орчин байгаад ч тус болохгүй нь ойлгомжтой.

Нөгөө талаар хоёр орны харилцааг ирээдүйд чиглүүлэн зөв гольдролоор өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө Япон улсын зүгээс ихээхэн хүчин чармайлт гаргасаар байгааг Ерөнхий сайдын айлчлалын үеэр болсон гол гол уулзалт ярианы явцаас харж болохоор байлаа. Монгол улстай эдийн засгийн хамтын ажиллагааг илүү үр өгөөжтэй, ашигтай хөгжүүлэхийн тулд Монголд үзүүлэх тусламжийн тусгай хөтөлбөр боловсруулахын зэрэгцээ Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэх бодолтой байгаагаа Ерөнхий сайд Ё.Мори мэдэгдсэн юм. Дашрамд тэмдэглэхэд Японы Засгийн газар нь үүнээс өмнө Вьетнам, Тайланд улсуудад тусламжийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн туршлагатай. Вьетнам улс 80-аад оны дунд үеэс Японы үйлдвэрүүдийг оруулж, жилдээ ойролцоогоор 300 сая ам. долларын зээл тусламжийг Япон улсын засгийн газраас авч ашиглаж иржээ. Одоо Японы засгийн газраас үзүүлж буй зээл, тусламжийн хэмжээгээр Вьетнам улс Хятадын / Жилд 1тэрбум доллар/ дараа хоёрдугаар байранд орж байна.

Дээрх тусламжийн тусгай хөтөлбөр боловсрогдож хэрэгжих нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чухал алхам болох нь дамжиггүй.

Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж байгаа гэдгээ дээрх айлчлалын үеэр Японы тал Ерөнхий сайд Н. Энхбаярт мэдэгдсэн юм. Монгол улсын унаган байгаль түүх, нүүдлийн өвөрмөц соёл иргэншил болон эдийн засаг, нийгмийн хүрээнд өрнөж буй өөрчлөлт нь дэлхийн улс орнууд түүний дотор Японы жуулчдын анхаарал сонирхлыг ихээхэн татаж байдаг юм. Жуулчлалыг хөгжүүлэх талаар манай улс ч их анхаарч, энэ салбарын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлаар холбогдох арга хэмжээг авч байна. 1999 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-г боловсруулж, үндэсний аялал жуулчлалын төвийг байгууллаа.

Япон улсад явуулсан судалгаанаас үзэхэд Монгол улсад

жуулчлах хүсэлтэй иргэд цөөнгүй хэдий ч үйлчилгээний үзүүдэлтээр хангалтгүй, аялалын зардал өндөр гэсэн үнэлгээ өгсөн байна. Статистикийн мэдээнээс үзэхэд гадаадын жуулчдын дийлэнх хувь нь Японоос, үлдэх хувь нь Баруун Европ, АНУ болон бусад улс орнуудаас ирж байна. Япон жуулчдыг голлон хүлээн авдгийн хувьд манай аялал жуулчлалын байгууллагууд Япон улсын ижил төрлийн байгууллагын туршлагыг үзэж судлах, тэднээс суралцах, аялал жуулчлалын ажилтнуудаа Япон улсад суралцуулах, үйл ажиллагааны түвшингээ ойртуулах талаар анхаарч ажиллах хэрэгтэй болов уу.

2001 оны тавдугаар сарын 15-16-нд Францын Парис хотноо Монголд хандивлагч орнуудын VIII уулзалт болж Монгол улсын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, ирэх 12 сарын хугацаанд 330 сая ам. долларын зээл, тусламжийг үзүүлэхээр боллоо⁴. Энэ зөвлөлгөөнөөр Япон улс хөнгөлөлттэй зээл 55,8 сая ам. доллар, буцалтгүй тусламж 58,9 сая ам. доллар, техникийн хамтын ажиллагааны шугамаар 21,8 сая ам. доллар нийтдээ 136,5 сая ам. долларын хөгжлийн албан ёсны тусламж⁵ олгохоор боллоо. Энэ нь хандивлагчдаас амласан нийт зээл тусламжийн 41,4%-тай тэнцэж байна. 2001 он гарсаар Япон улсын засгийн газраас IV цахилгаан станцийн шинэчлэлд зориулж 6,1 тэрбум иен⁶, “Улаанбаатар хотын авто замыг сайжруулах” төслийг хэрэгжүүлэхэд 1 тэрбум 643 сая иен, “Төмөр замын байгууламжийг сайжруулах / үер, нурангаас хамгаалах / “ төсөлд 869 сая иений үнийн дүнтэй тэнцэх буцалтгүй тусламж⁷-ийг тус тус олгохоор гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж төслүүд хэрэгжиж эхлээд байна. Түүнээс гадна 2000 оны зудын хохирлыг арилгахад зориулж Япон улсын засгийн газраас 13 сая долларын яаралтай буцалтгүй тусламжийг үзүүлсэн билээ. Япон улсаас үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ 1999 оноос хойш жилд дунджаар 16,3 хувиар өсөж ирэв.⁸ Харин тусламжийн тоо хэмжээг жилээс жилд өсгөж ирэхдээ хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэг түвшинд барих, эргэж төлөгдөх нөхцлийг судалж үзсэний үндсэн дээр зээлийг олгох зэрэг чиг бодлогыг барьж ирсэн бөгөөд энэ нь чухамдаа Монгол улсыг ирээдүйд өрийн дарамтанд унагахгүй байх зорилго агуулсан сайн санааны илрэл чухал ач холбогдолтой алхам юм. Харин манай талын хувьд Япон улсаас өгч буй тусламж зээлийг

хамгийн зүй зохистой, үр өгөөжтэйгөөр ашиглах, тусламж авах урьдчилсан судалгаа хийх, хүсэлт гаргах шатнаас эхлээд төслийг хэрэгжүүлж дуусах, тусламжаар бий болсон объектийг амьдрал ахуйд ашиглах, хөнгөлөлттэй зээлийг бол эргүүлэн төлж дуусгах хүртэлх бүх явцад тусламжийн утга учрыг ойлгож, үүрэг хариуцлагаа өндөржүүлж, ажил хэрэгчээр хандаж чадвал зээл тусламж жинхэнэ ёсоороо үр дүнд хүрэх биз ээ.

Хоёр орны хамтын ажиллагааны хамгийн ирээдүйтэй, хамгийн ач холбогдолтой хэлбэрийн нэг нь оюутан, залуусын солилцоо, хөдөлмөрийн дадлага эзэмшигч нарын сургалт үйлдвэрлэлийн дадлагын хэрэгжилт юм. Манай хоёр улс 1998 онд гаргасан хамтарсан мэдэгдэлдээ соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутан, залуучуудын солилцоог нэмэгдүүлэхийн ач холбогдолын тухайд санал нэгтэй байгаагаа тэмдэглэсэн юм. Боловсролын солилцоог цаашид нэмэгдүүлж, 20-иод оюутныг Японы зардлаар нэмж сургахаар 2001 оны хоёрдугаар сард хоёр улсын засгийн газар тохиролцсон билээ. Ялангуяа Монголын малчин ардын хүүхдүүдийг мэдээллийн технологийн мэрэгжлээр Япон улсын зардлаар суралцуулах саналыг Японы талаас тавьсан нь нэгд, орчин үед зайлшгүй шаардлагатай болж буй шинэ салбарын боловсон хүчнээ дэлхийн тэргүүний хөгжилтэй улсад бэлтгэж авах олдошгүй боломж, хоёрт, сүүлийн үед манай боловсролын салбарт илт ажиглагдах болсон малчин ардын хүүхдүүд гадаадад боловсрол олж авах асуудал хойш хаягдсаар ирсэн өрөөсгөл гажиг хандлагыг соргог мэдэрсэн, манай орны ирээдүйд чухал ач холбогдолтой тусламж юм.

□Япон улсын зүгээс монгол оюутнуудыг хүлээн авч суралцуулах асуудлыг идэвхтэй хөхүүлэн дэмжсээр ирсэн бөгөөд хувийн зардлаараа сурч буй оюутны хөнгөлөлтийн асуудлыг ч судалж үзэж байна. Монголын хөгжилд Япон улс ямагт идэвхтэй дэмжлэг үзүүлэх болно”⁹ хэмээн Ерөнхий сайд Ё.Мори Монгол улсын Засгийн газрын Ерөнхий сайд Н.Энхбаярын Япон улсад хийсэн айлчлалын үеэр мэдэгдсэн юм.

Боловсролын солилцооны зэрэгцээ сүүлийн үед манай улсаас үйлдвэрлэлийн дадлага эзэмшигч, мэрэгжлийн ур чадвар дээшлүүлэгч нарыг Япон улсад илгээж үйлдвэрлэл дээр ажиллуулах хэлбэрийн хамтын ажиллагаа хэрэгжиж эхэлсэн нь манай улсын ирээдүйд чухал үр дүнгээ өгөх ажил юм. Манай улсын Эрүүл мэнд, Нийгмийн

хамгааллын яам, Японы олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага / JTCO /-ын хооронд манай иргэдийг Япон улсад үйлдвэрлэлийн дадлага эзэмшүүлэх талаар хоёр байгууллагын хооронд хамтран ажиллах тухай санамж бичигт 1998 оны есдүгээр сард гарын үсэг зурсан юм. Хоёр байгууллагын хамтын ажиллагааны шугамаар дээрх санамж бичгийн үндсэн дээр 1998-2000 онд 200-аад хүн Япон улсад очиж, Нийгата, Ибараги, Сайтама зэрэг мужуудад үйлдвэрлэлийн дадлага эзэмшин ажиллаж байна. Япон улсад үйлдвэрлэлийн дадлага эзэмших иргэдийг зуучлан ажиллах байгууллагаар манай улсын “Заг” ХХК, “Монгол Ньюс” ХХК, “Ти Си Ай” ХХК, “Мөхөт” ХХК, “Бридж” ХХК, “Их хийморь төв” зэрэг байгууллагууд ажиллаж байна.

Япон улсад үйлдвэрлэлийн дадлагаар гэрээний үндсэн дээр монгол иргэдийг ажиллуулах нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд тус дэм болохоос гадна монгол иргэд японд ажилласнаар японы үйлдвэрийн өндөр технологиос суралцаж, үйлдвэрлэлийн дадлага ур чадварын мэдлэг эзэмшин, иргэд өөрсдийнхөө амьдрал ахуйг дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх таатай боломж бүрдэж, улмаар эх орныхоо нийгэм эдийн засгийн болон үйлдвэрлэлийн хөгжлийг хангахад чухал хувь нэмэр оруулах ирээдүйг чиглэсэн үйл ажиллагааны эхлэл юм. Залуучуудыг өндөр хөгжилтэй оронд хууль, гэрээ хэлэлцээрийн дагуу явуулж ажиллуулах нь хувь хүн насан туршдаа хэрэглэх ажил хөдөлмөр, зах зээлийн нийгмийн амьдралын мэдлэг туршлага эзэмшихээс гадна түүгээр дамжин улс орны ирээдүйд ач холбогдолоо өгөх томоохон хөрөнгө оруулалт хийж байгаа хэрэг юм. Нөгөө талаар Япон улс нь хөгжлийнхөө тодорхой шатанд, үндэсний эдийн засгаа орчин үеийн болгож хөгжүүлэх үедээ өөрөөр хэлбэл одоогоос 100-аад жилийн өмнө залуучуудаа мянга мянгаар нь барууны орнуудад илгээж тэдгээр орнуудын үйлдвэрлэл, технологиос суралцуулж байсан туршлагатай улс. Эх орондоо буцаж ирээд бүтээн байгуулалтад оролцсон тэдгээр залуусын хөдөлмөр хүчин зүтгэл, нөгөө талаар Японд ажиллаж байсан гадаадын шилдэг мэргэжилтнүүдээс заалгаж эзэмшсэн туршлагын хүчинд Япон улс бүх талаар тэргүүний орон болж чадсан нь түүхэн бодит байдал юм. Тиймээс чухам Япон оронд ажиллах хүчнээ явуулж, үйлдвэрлэл, ажил амьдралын мэдлэг туршлага суулгах нь бусад улсад ажиллах хүчин илгээхээс илүү утга учиртай,

манай улсын ирээдүйд илүү нөлөөтэй байж ч болох юм.

Орчин үеийн дэлхий нийтийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхаж , нийгэм эдийн засгийн дэвшлийн илүү боломжийг нээх, хүмүүсийн хоорондын харилцаа холбоог өргөтгөх шинэ шинэ салбарт Япон улстай харилцах харилцаагаа улам өргөтгөх, хамтын ажиллагааны хэтийн төлөв шинээр нээгдсээр байна. Үүний нэг жишээ бол мэдээллийн технологийн салбарт Япон улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан Бунка Ориент Монгол Компани юм. Мэдээллийн технологийн салбарт экспорт хийх шинэ зорилго бүхий энэ компанийг компьютер, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг Монголын БСБ компани Японы Бунка Ориент Корпорацитай хамтран байгуулжээ. Японы Бунка Ориент Корпораци нь Японы боловсролын салбар дахь программ хангамжийн зах зээлийн 70 хувийг хангадаг, дэлхийн зах зээлд БНХАУ, Энэтхэг, АНУ-д байрласан 10 гаруй салбараараа дамжуулан ажилладаг, Майкро софтын гэрчилгээгээр батламжлагдсан шийдэл боловсруулагч, сургалт зохион байгуулагч ажээ. Хоёр орны хамтын ажиллагааны үр дүнд мэдээлэл технологийн өнөө үед Монгол улсад мэдээллийн салбарт экспортыг нэмэгдүүлэх шинэ салбар үүсэн байгуулагдсан нь манай улсын мэдээллийн технологийн мэдлэг боловсролыг улам дээшлүүлж цаашдаа Монгол улсын эдийн засаг, үйлдвэрлэлийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах биз ээ.

Шинээр эхэлж буй эдгээр салбаруудаас гадна Монгол улсын эдийн засгийн уламжлалт голлох салбар болсон мал аж ахуйд Японтой хамтран ажиллаж малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эм био бэлдмэлийн үйлдвэрлэл, түүхий эдийг боловсруулах талаар хамтарсан судалгаа шинжилгээний ажил явуулах, төсөл хэрэгжүүлэх олон хэлбэр байж болох юм. Хөдөө аж ахуйд шинэ техник технологи нэвтрүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, малын тэжээл үйлдвэрлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг оврын машин техникийн судалгааг явуулах, энэ чиглэлийн арга технологи нэвтрүүлэх, өөрөөр хэлбэл Япон улс шинжлэх ухаан техникийн дэвшлийг хөдөө аж ахуйдаа шууд нэвтрүүлж буй туршлагыг судлах хэрэгцээ шаардлага улам өсч байна.

Монгол улс зах зээлийн багтаамж багатай, экспортын бүтээгдэхүүн хязгаартай, төлбөрийн чадвар сул учраас гадаад

худалдааг улс бүхэнтэй өргөжүүлж чадахгүй нь мэдээж боловч, худалдааны уламжлалт харилцаатай, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанараар дэлхийд тэргүүлдэг Япон улстай худалдааг илүүтэй хөгжүүлэх шаардлага хэрэгцээ улам өсч байна. Хоёр орны худалдааг өргөтгөх талаар Япон улсын зүгээс ч дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн бөгөөд 2001 оны аравдугаар сард Японд “Монголын барааны үзэсгэлэн худалдаа”-г амжилттай зохион байгууллаа.

Ийнхүү Монгол Японы харилцааны шинэ зууны гараа цар далайцтай, ирмүүн өнгө аястай эхэллээ. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн хүрээд буй түвшин-иж бүрэн түншлэлийн харилцааны үндэс суурийг улам бататган, цаашид элдэв гажуудал бэрхшээлээс ангид зөв гольдрилоор авч явж чадаж гэмээнэ, Монгол улсад ардчиллыг хөгжүүлж, нийгэм эдийн засгийн шинэ харилцааг бэхжүүлэх улс орны ирээдүйн хөгжлийн эрх ашигт нийцсэн чухал хүчин зүйл байсаар байх болно гэдэгт маргах хүн үгүй биз ээ.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

- 1 Ардын эрх . 1998. 5.15. № 114 /1893/
- 2 Ардын эрх. 1998. 5. 14. № 113. /1892/
- 3 Зууны мэдээ. 2001. 2. 17. № 41 /615/
- 4 Зууны мэдээ. 2001. 5. 18.
- 5 Өнөөдөр. 2001. 2. 17.
- 6 Зууны мэдээ . 2001. 2. 17.
- 7 Зууны мэдээ. 2001. 6. 6.
- 8 Монгол-Японы харилцаа: эрт эдүгээ. УБ. 1998. х. 36
- 9 Зууны мэдээ. 2001. 2. 17.